

**ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ**(Иргэний эрх зүйн маргаан¹)**ВИРТУАЛ СЕРВЕР ДЭХ ХЭРЭГЛЭГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ АЮУЛГҮЙ ХАДГАЛАХ,
НӨӨЦЛӨХ ҮҮРГИЙГ СЕРВЕР НИЙЛҮҮЛЭГЧ ХҮЛЭЭНЭ**

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2025/00208

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 11 сарын 18-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг шийдлийн хувьд хэвээр үлдээж, шийдвэр, магадлалд хууль хэрэглээний өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч “К” ХХК нь хариуцагч “А” ХХК-д холбогдуулан 305,628,766 төгрөгийг гаргуулах нэхэмжлэл гаргаж үндэслэлээ “талуудын хооронд байгуулагдсан “Клауд.мн үйлчилгээний гэрээ”-ний үүргээ биелүүлээгүй түүний буруутай үйл ажиллагаанаас болж манай байгууллагын чухал мэдээлэл буюу албан ёсны бүртгэлтэй харилцагч, зээлдэгч нарынхаа бүрэн мэдээлэл, төрийн мэдээллийн сангуудаас төлбөр төлж авсан үндсэн дата мэдээллүүд устаж үгүй болсон. Иймд мэдээллийг дахин бүрдүүлэхэд гарсан зардал, ... шинээр 14 ажилтан ажиллуулсан ...төгрөг, их хэмжээний нэмэлт зардал гаргасан тул хохирлыг барагдуулж өгнө үү” гэж тодорхойлжээ.

Хариуцагч “А” ХХК нь нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч маргахдаа “Гэрээний заалтууд зөрчигдсөн тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлт, шийдвэр гараагүй, урьдчилсан байдлаар үүссэн асуудлыг системийн шинэчлэл хийгдэх явцад технологийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан гэх дүгнэлтийг бид хийсэн. Нэхэмжлэгч нь гэрээний 2.8-д заасан “Нөөцлөлт (backup) буюу ... нөөцлөлтийн үйлчилгээ”-г аваагүй байсан. Энэ нөхцөлд үйлчлүүлэгч нь үүсэж болох эрсдэлийг өөрөө хариуцах талаар гэрээний 5.13-т заасан. Хэрэв хэрэглэгч өөрийн мэдээллийг нөөцөлж хадгалж байсан бол мэдээлэл бүрэн устахгүй, дахин татаж авах, ашиглах боломжтой байх байсан. Нэхэмжлэлийн шаардлага тодорхойгүй буюу

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/10966?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1



шаардаж байгаа зүйл нь мэдээлэл утсан болон гэрээтэй ямар холбоотой нь тодорхойгүй” гэж маргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүх:** “Зохигч үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрсний үндсэн дээр гэрээг цахимаар байгуулан, агуулгын талаар маргаагүй тул Иргэний хуулийн 42¹.1², 42¹.2-т³ нийцсэн хүчин төгөлдөр гэрээ гэж үзэхээр байна. Клауд үйлчилгээ үзүүлэх гэрээнээс үзэхэд нэхэмжлэгч нь өөрийн харилцагч нарт цахим зээлийн үйлчилгээ үзүүлэх программ, түүнд суурилсан **дата мэдээллийг хариуцагчийн серверийн тодорхой хэсэгт хадгалуулах, улмаар төлбөр төлөхөөр тохиролцсон байх тул талуудын хооронд Иргэний хуулийн 318.1-т⁴ заасан түрээсийн гэрээний харилцаа үүссэн гэж үзлээ.** Серверт хадгалагдаж байсан мэдээлэл утсан явдалд хариуцагч буруутай гэдэг нь тогтоогдоогүй түүнчлэн учирсан гэх хохирол нь санхүүгийн анхан шатны баримтаар нотлогдоогүй, нэхэмжлэгчийн өөрийн үйл ажиллагааны зардал байх тул нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.” (7)⁵
2. **Давж заалдах шатны шүүх:** Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэхдээ “...Клауд серверт хадгалагдаж байсан “К” ХХК-ийн мэдээлэл ... өдөр утсан ба зохигчийн хэний буруутай үйлдлээс шалтгаалж мэдээлэл утсан нь маргааны зүйл болжээ. “А” ХК нь тус өдөр системийн шинэчлэл хийхдээ клауд серверийн үйлчилгээний найдвартай ажиллагааг хангаж ажиллаагүйгээс “К” ХХК-ийн үүсгэсэн сервер дэх мэдээлэл утжээ. Анхан шатны шүүх тус харилцааг бусдын эзэмшил, ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой үүргийн харилцааны төрөл болох түрээсийн гэрээ гэж дүгнэсэн нь оновчгүй байна. Уг гэрээгээр нэг талаас нийлүүлэгч нь хэрэглэгчид клауд сервер үүсгэх үйлчилгээ үзүүлэх, үүсгэсэн клауд серверийн ажиллагаа, багтаамж, сүлжээний холболтын найдвартай байдлыг хариуцах, нөгөө талаас хэрэглэгч нь үүсгэсэн клауд серверт мэдээллээ хадгалж, төлбөр төлөхөөр тохиролцсон, **гэрээний зүйл нь үйлчилгээ үзүүлэх байх тул талуудын хооронд Иргэний хуулийн 359.1-т⁶ заасан хөлсөөр ажиллах гэрээ байгуулагдсан гэж дүгнэх үндэслэлтэй.** (3)

² Иргэний хуулийн 42¹ дүгээр зүйлийн 42¹.1 “Хуульд зааснаар бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлбэл зохих болон бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно.”

³ Иргэний хуулийн 42¹ дүгээр зүйлийн 42¹.2 “Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж, цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлж, харилцан хүлээн зөвшөөрч, цахим гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.”

⁴ Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.1 “Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.”

⁵ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

⁶ Иргэний хуулийн 359 дүгээр зүйлийн 359.1 “Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажиллуулагч хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.”



Иймд Иргэний хуулийн 219.1-т⁷ зааснаар “А” ХК нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн нь тогтоогдсон тул нэхэмжлэгч хохирол төлөхийг хариуцагчаас шаардах эрхтэй. Хариуцагчийн үүргийн зөрчилтэй шалтгаант холбоотой, хэргийн нотлох баримтаар тогтоогдсон хэмжээнд хохиролд 41,440,568 төгрөгийг хариуцагчаас гаргуулан нэхэмжлэгчид олгож, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй” гэж шийдвэрлэжээ.

3. **Хяналтын шатны шүүх:** “Талуудын байгуулсан гэрээнээс үзэхэд “К” ХХК нь хэрэглэгч бөгөөд цахим зээлийн үйл ажиллагаа явуулахдаа хамаарах мэдээллийг нийлүүлэгч буюу “А” ХХК-ийн Клауд.мн серверт байршуулж, хадгалж, ашиглах зорилготой байна. Хэрэглэгч программ хангамжийг биетээр хүлээн авдаггүй ч интернэтээр дамжуулан нэвтрэх, ашиглах эрхтэй ба программ хангамж нь нийлүүлэгчийн сервер дээр биежсэн байдлаар оршдогоороо түрээсийн гэрээний аж ахуйн үйл ажиллагаа явуулах, дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх шинжийг агуулсан байж болно.
4. Гэрээнд зааснаар хэрэглэгч өөрийн дата, мэдээллийг аюулгүй хадгалах, найдвартай, үл тасалдах серверт байршуулах зэрэг нь гэрээний гол нөхцөл болохын сацуу нийлүүлэгчээс хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээнд хамаарч байгаагаас үзэхэд гэрээг бүхэлд нь түрээсийн гэрээ гэж үзэх үндэслэлгүй. Талуудын байгуулсан гэрээ нь олон янзын гэрээний шинжийг агуулж байгаа ч аль нэг нь дангаараа давамгайлсан шинжгүй тул Иргэний хуульд заасан тодорхой нэг гэрээний төрөлд бүхэлдээ хамаарахгүй. Тиймээс Иргэний хуулийн 189.5-д⁸ зааснаар нэрлэгдээгүй гэрээ гэж үзлээ. (18)
5. “А” ХХК нь гэрээний дагуу үйлчилгээний найдвартай байдлыг хариуцах үүрэгтэй учир серверт байршуулсан мэдээлэл устаж авах боломжгүй болсон нь хариуцагчийг тухайн үүргээ зөрчсөн гэж үзнэ. (23) Хариуцагч “К” ХХК-г гэрээнд зааснаар нөөцлөх үйлчилгээг нэмэлтээр аваагүй тул үр дагаврыг хариуцахгүй гэж тайлбарласан нь үндэслэлгүй. Гэрээний онцлог нь серверийг саадгүй ашиглах нөхцөлийг нийлүүлэгч хангах юм. Хэрэглэгч гэрээгээр тохирсон үйлчилгээг авах боломжгүй болсон нь гэрээний үндсэн үүрэг зөрчигдсөн гэж үзэх ба уг нөхцөл байдал нь нөөцлөх үйлчилгээтэй хамааралгүй байна. (24) Иймд Иргэний хуулийн 189.5, 219.1-т заасныг баримтлан нэхэмжлэгчийн утсан мэдээллийг сэргээхтэй холбоотойгоор гаргасан 41,440,568 төгрөгийн зардлыг гаргуулах нь үндэслэлтэй” гэж шийдвэрлэжээ.

---o0o---

⁷ Иргэний хуулийн 219 дүгээр зүйлийн 219.1 “Үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй.”

⁸ Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.5 “Энэ хуулиар зохицуулаагүй, шууд нэрлэгдээгүй боловч гэрээний үндсэн шинж, хэлбэрийг илэрхийлсэн өвөрмөц агуулга бүхий гэрээг нэрлэгдээгүй гэрээ гэнэ. Нэрлэгдээгүй гэрээнд энэ хуулийн үүргийн тухай нийтлэг үндэслэл хамаарна.”